



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 0/22

Хархорин сум

Эзэмшил газрын байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.6 дэх заалтыг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Самдангийн Ганбаярын гаргасан хүсэлтийн дагуу Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор зориулалтаар эзэмшиж байгаа 2 дугаар багийн нутаг дэвсгэр Дэнж 1-6 тоотод байрлалтай 6209005634 нэгж талбарын дугаартай 1000м² газрыг хаяг хэмжээ өөрчлөхгүйгээр $X=334436.73$, $Y=5229007.56$, $X=334428.67$, $Y=5229027.22$, $X=334485.38$, $Y=5229043.68$, $X=334489.27$ $Y=5229031.11$ тус координатаар байршлыг өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Самдангийн Ганбаярт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт зөвшөөрсүгэй.

3.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (С.Ганбаяр)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2024 оны А/10 дугаар захирамжийн холбогдох хэсэг, газар эзэмших эрхийн 0000263642 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100043